



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/49

Хажуу шинэ-Ус

Бүх нийтийн цэвэрлэгээ зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.12, 9.5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Говь-Угтаал сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд хаврын бүх нийтийн цэвэрлэгээг 2023 оны 05 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. 2023 оны 05 сарын 17-ны өдөр албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх бүр 50 метр газраа цэвэрлэх 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр албан байгууллага аж ахуйн нэгж, иргэд нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг сумын төвийн багийн Засаг дарга (Л.Батбаатар)-т үүрэг болгосугай.

3. Их цэвэрлэгээнээс гарсан үүсмэл хог хаягдлыг цаг хугацаанд нь тээвэрлэх ажлыг сумын төвийн багийн засаг даргатай хамтран зохион байгуулж ажиллахыг Засаг даргын орлогчийн ажлыг түр орлон гүйцэтгэгч (Б.Даваасүрэн)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох)-д даалгасугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоож бүгд хамрагдахад анхаарч ажиллахыг сумын хэсгийн төлөөлөгч (Э.Ванчиндорж), цагдаа (Б.Наранбаатар) нарт даалгасугай.

ДАРГА  Т.АРИУНАА

